



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 8/28

Жаргалтхаан сум

“Хүүхэд хамгааллын багийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэх заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/612 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан журам, “Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/453 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан журам, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/214 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан чиглэл, Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын сайд, Хууль Зүй Дотоод Хэргийн сайдын хамтарсан 2017 оны А/120, А/178 дугаар тушаалаар батлагдсан “Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам”- ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/453 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”- ыг хэрэгжүүлэх хүүхэд хамгааллын багийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Багийн ахлагч: С.Оюунцэцэг (Захирал)

Нарийн бичиг: О.Түвшинбаяр (Нийгмийн ажилтан)

Гишүүд: Д.Бямбадорж (Сургалтын менежер)

Э.Батболд (Дотуур байрын багш)

Ж.Хүрэлцэцэг (Бага ангийн багш)

Д.Алтангэрэл (Дуу хөгжмийн багш)

2. Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын талаарх холбогдох хууль, дүрэм, журам, чиглэлийн хэрэгжилтийг ханган ажиллахыг нарийн бичиг О.Түвшинбаяр, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбоотойгоор 2022 оны 04 дүгээр сарын 22 – ны өдрийн “Сургуулийн хүүхэд хамгааллын зөвлөл” – ийн тушаалыг хүчингүй болгосугай.

ЗАХИРАЛ

С.ОЮУНЦЭЦЭГ



D/Tushaal-2025

232501055